

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**ХОВД АЙМГИЙН УС ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН 2020 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Аудитын код: ХОА-2021/109/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Ховд хот
2021 он

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 70433061

Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545

Цахим хаяг: Tsetsegsuren.A@audit.gov.mn

Ахлах аудитор: Ц.Гантулга

Утас: 70432545

цахим хаяг: Gantulga.TS@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	<i>Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт</i>
АОУС	<i>Аудитын Олон Улсын Стандарт</i>
УСНББОУС	<i>Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт</i>
ТТЗ	<i>Төсвийн төвлөрүүлэн захирагч</i>
ТШЗ	<i>Төсвийн шууд захирагч</i>
ЦУОШГ	<i>Цаг уур орчны шинжилгээний газар</i>
ЗДТГ	<i>Засаг даргын тамгын газар</i>
ЦАЗН	<i>Цаг агаар зориудаар нөлөөлөх</i>
ХАА	<i>Хөдөө аж ахуй</i>

Агуулга

1.ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН.....	5
2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН.....	6
2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН.....	7
2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН.....	10
2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН.....	10
2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН.....	12
3.АУДИТЫН ТАЙЛАН.....	12
3.1. Ерөнхий зүйл.....	12
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	13
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт.....	13
3.4. Материаллаг байдал.....	14
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	14
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт.....	15
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	15
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
3.9. Аудитын илрүүлэлт.....	16
Залруулсан алдаа.....	16
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил.....	16
3.0. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	17
4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ.....	17
5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ.....	17

1. ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2021.02.18 № 2/64
танай _____ -ны № _____ -г

УС ЦАГ УУР ОРЧНЫ
ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН
ДАРГА А.ЭНХЗАЯА ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны Ус цаг уур орчны шинжилгээний төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ус цаг уур орчны шинжилгээний төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, үйл ажиллагааны тайлан, цаг уурын урьдчилан сэрэмжлүүлгийн мэдээний бодит байдал, уур амьсгалын судалгаа, нислэгийн цаг уурын бодит мэдээлэл, цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаа зэрэг санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

021020435

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН
2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/			
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>114,646,721.44</u>	<u>94,996381,11</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	113,976,721.44	94,996381,11
351	Түүхий эд материал	72,862,601.10	62,480762,07
35110	Тусгай зориулалттай материал	72,862,601.10	62,480762,07
354	Хангамжийн материал	41,114,120.34	32,515,619.04
35410	Бичиг хэргийн материал	1,788,240.00	884,000.00
35420	Аж ахуйн материал	6,998,500.00	5,534,500.00
35430	Сэлбэг хэрэгсэл	2,150,000.00	7,480,000.00
35440	Түлш, шатах тослох материал	30,177,380.34	18,617,119.04
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>839,114,379.35</u>	<u>803,406,451.26</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	839,114,379.35	803,406,451.26
392	Биет хөрөнгө	598,655,825.91	579,408,044.40
39201	Барилга, байгууламж, орон сууц	451,153,017.00	451,153,017.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-23,890,876.05	-46,264,228.99
39203	Авто-тээврийн хэрэгсэл	399,541,818.00	458,229,391.78
39204	Хуримтлагдсан элэгдэл	-383,360,000.00	-390,796,780.04
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	688,479,583.73	685,592,538.11
39206	Хуримтлагдсан элэгдэл	-541,120,159.93	-585,382,474.21
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	32,177,145.22	14,312,114.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-24,474,352.06	-7,585,183.25
39217	Ном	149,650.00	149,650.00
393	Биет бус хөрөнгө	240,458,553.44	223,998,406.86
39301	Програм хангамж	680,636.00	275,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-680,636.00	-275,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	258,052,948.50	258,452,948.50
39304	Хуримтлагдсан элэгдэл	-17,594,395.06	-34,454,541.64
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>953,761,100.79</u>	<u>898,402832,37</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>953,761,100.79</u>	<u>898,402832,37</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	953,761,100.79	898,402832.37
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,221,235,417.47	1,221,235,417.47
51101	Өмч: - төрийн	1,221,235,417.47	1,221,235,417.47
512	Хуримтлагдсан үр дүн	-523,245,630.12	-579,747,802.39
51210	Өмнөх үеийн үр дүн	-523,245,630.12	-524,312,933.97
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-55,358268,42
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	255,771,313.44	256,838,617.29
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>953,761,100.79</u>	<u>898,402832,37</u>

2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/			
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1212201375.00	1,711070020.07
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	122852472.00	135345508,07
120	Нийтлэг татварын бус орлого	122852472.00	135,345508,07
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	122852472.00	135,345508.07
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	307,600.00	14,800.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	122852472.00	135,330708.07
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1089348903.00	1,575,724,512.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1056173900.00	1,542,082,584.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1056173900.00	1,542,082,584.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	23100000.00	32,337,440.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	18100000.00	18043760.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлого		6500000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,000,000.00	7,793,680.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	10075003.00	1,304,488.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	10075003.00	1,304,488.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1 149782473.60	1,766,428,288.49
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1149782473.60	1,766,428,288.49
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1139399870.60	1,517,459,215.59
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	880538059.00	1,099,467,655.65
210101	Үндсэн цалин	880538059.00	1,099,467,655.65
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	110215059.00	136,972,054.31
210201	Тэтгэврийн даатгал	74833033.00	93,397,756.00
210202	Тэтгэмжийн даатгал	8577394.00	11,656,681.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	8577394.00	8,286,439.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1760593.00	2,012,997.00
210205	Эрүүл мэндийн даатгал	17605522.00	21,618,181.31
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	33703764.00	36,356,100.00

210301	Гэрэл, цахилгаан	2250000.00	8,587,600.00
210302	Түлш, халаалт	27937764.00	24,402,500.00
210303	Цэвэр, бохир ус	3516000.00	3,366,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	30585690.00	57,735,862.40
210401	Бичиг хэрэг	5466494.00	4,946,588.40
210402	Тээвэр, шатахуун	17350420.00	47,750,060.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1793976.00	1,531,414.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5974800.00	3,507,800.00
2105	Нормативт зардал	1273750.00	41,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1273750.00	41,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3476664.00	1,378,289.14
210601	Багаж, техник, хэрэгсэл	61000.00	653,889.14
210604	Урсгал засвар	3415664.00	724,400.00
2107	Томилолт, зочны зардал	59292100.00	4,755,630.00
210702	Дотоод албан томилолт	5292100.00	4,755,630.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9665544.00	5,877,136.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8860544.00	5,036,950.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	198000.00	198,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	297000.00	216,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	116,600.00	116,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	59,400.00	59,400.00
210807	Газрын төлбөр	00.00	249,786.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	64349260.60	174,875,488.09
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	39,507,901.33
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	320820.00	1,490,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	64028420.60	133,877,586.76
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10382603.00	248,969,072.90
2132	Бусад урсгал шилжүүлэг	10075003.00	246,911,916.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	10075003.00	1,304,488.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	245,607,428.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	2,057,156.90
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	307600.00	2,057,156.90
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	62418901.40	-55,358268.42
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	62418901.40	-55,358268.42

2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1089348903.00	1,575,739,312.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1089348903.00	14,800.00
120	Нийтлэг татварын бус орлого	307,600.00	14,800.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	307,600.00	14,800.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	307,600.00	14,800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1089348903.00	1,575,724,512.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1089348903.00	1,542,082,584.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1056173900.00	1,542,082,584.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	23100000.00	32,337,440.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	18100000.00	18043760.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,000,000.00	7,793,680.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		6500000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	10075003.00	1,304,488.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	10075003.00	1,304,488.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	10870679603.00	1,575,339,312.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1087067603.00	1,575,339,312.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1076685000.00	1,326,370,239.10
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	883254300.00	1,089,100,199.10
210101	Үндсэн цалин	725072600.00	789,161,700.00
210102	Нэмэгдэл	126736800.00	268,493,599.10
210103	Унаа хоолны хөнгөлөлт	31444900.00	31,444,900.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	110406600.00	147,028,400.00
210201	Тэтгэврийн даатгал	75250000.00	103,464,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	8789100.00	10,891,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7031400.00	8,712,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1757800.00	2,178,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	17578300.00	21,782,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32371600.00	36,339,100.00

210301	Гэрэл, цахилгаан	4040000.00	8,587,600.00
210302	Түлш, халаалт	24815600.00	24,385,500.00
210303	Цэвэр, бохир ус	3516000.00	3,366,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	25387500.00	29,474,560.00
210401	Бичиг хэрэг	2546200.00	2,749,300.00
210402	Тээвэр, шатахуун	19475700.00	24,266,660.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2345300.00	1,738,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1020300.00	720,500.00
2105	Нормативт зардал	3301500.00	481,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3301500.00	481,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5447500.00	7,524,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2831400.00	6,367,500.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	185,300.00	185,300.00
210604	Урсгал засвар	2430800.00	972,000.00
2107	Томилолт, зочны зардал	5599700.00	4,755,630.00
210702	Дотоод албан томилолт	5599700.00	4,755,630.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10495600.00	9,877,550.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9360600.00	8,907,150.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	198000.00	198,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	297000.00	216,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	116,600.00	116,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	59,400.00	59,400.00
210807	Газрын төлбөр	434000.00	380,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	420700.00	1,789,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	420700.00	1,789,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10382603.00	248,969,072.90
2132	Бусад урсгал шилжүүлэг	10075003.00	246,911,916.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	10075003.00	1,304,488.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	245,607,428.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	2,057,156.90
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	2,057,156.90
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	2281300.00	400,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	2588900.00	400,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2588900.00	400,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр		400,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	2588900.00	400,000.00

6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-2588900.00	-400,000.00
---	--	--------------------	--------------------

2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,221,235,417.47	255,771,313.44	-523,245,630.12	953,761,100.79
D01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,221,235,417.47	255,771,313.44	-523,245,630.12	953,761,100.79
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	-1,067,303.85	-1,067,303.85
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,221,235,417.47	255,771,313.44	-524,312,933.97	952,693,796.94
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	1,067,303.85	00.00	1,067,303.85
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-55,358268.42	-55,358268.42
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,221,235,417.47	256,838,617.29	-579,747,802.39	898,402832.37

2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,545,889,700.00	1,542,082,584.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,545,889,700.00	1,542,082,584.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,295,465,900.00	1,294,417,999.10
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,089,100,200.00	1,089,100,199.10
210101	Үндсэн цалин	789,161,700.00	789,161,700.00
210102	Нэмэгдэл	268,493,600.00	268,493,599.10
210103	Унаа хоолны хөнгөлөлт	31,444,900.00	31,444,900.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	147,028,400.00	147,028,400.00
210201	Тэтгэврийн даатгал	103,464,400.00	103,464,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	10,891,000.00	10,891,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,712,800.00	8,712,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,178,200.00	2,178,200.00

210205	Эрүүл мэндийн даатгал	21,782,000.00	21,782,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	36,339,100.00	36,339,100.00
210301	Гэрэл, цахилгаан	8,587,600.00	8,587,600.00
210302	Түлш, халаалт	24,385,500.00	24,385,500.00
210303	Цэвэр, бохир ус	3,366,000.00	3,366,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,133,400.00	10,091,400.00
210401	Бичиг хэрэг	1,547,600.00	1,545,900.00
210402	Тээвэр, шатахуун	6,586,900.00	6,586,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,738,100.00	1,738,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	260,800.00	220,500.00
2105	Нормативт зардал	481,000.00	481,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	481,000.00	481,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,070,800.00	2,070,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	913,500.00	913,500.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	185,300.00	185,300.00
210604	Урсгал засвар	972,000.00	972,000.00
2107	Томилолт, зочны зардал	3,022,300.00	2,761,350.00
210702	Дотоод албан томилолт	3,022,300.00	2,761,350.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,000,200.00	6,346,750.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,895,200.00	5,391,150.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	198,000.00	198,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	297,000.00	201,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	116,600.00	116,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	59,400.00	59,400.00
210807	Газрын төлбөр	434,000.00	380,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	290500.00	199000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	290,500.00	199,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	250423800.00	247664584.90
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	00.00	2,057,156.90
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	00.00	2,057,156.90
2132	Бусад урсгал шилжүүлэг	250,423,800.00	245,607,428.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	250,423,800.00	245,607,428.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,545,889,700.00	1,542,082,584.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,545,889,700.00	1,542,082,584.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,545,889,700.00	1,542,082,584.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	95.00	95.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	88.00	88.00
620003	Үйлчлэх ажилтан	06.00	06.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	00.00	97.00

650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	00.00	95.00
650010	Гэрээт ажилтан	00.00	02.00

2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	32337440.00	32,337,440.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	32337440.00	32,337,440.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	32337440.00	32,337,440.00
2104	Хангамж, бараа материалын зардал	19383160.00	19,383,160.00
210401	Бичиг хэрэг	1203400.00	1,203,400.00
210402	Тээвэр, шатахуун	17679760.00	17,679,760.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	500000.00	500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5700000.00	5,700,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5700000.00	5,700,000.00
2107	Томилолт, зочны зардал	1994280.00	1,994,280.00
210702	Дотоод албан томилолт	1994280.00	1,994,280.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3670000.00	3,670,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3670000.00	3,670,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1590000.00	1,590,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1590000.00	1,590,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	32337440.00	32337440.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	32337440.00	32,337,440.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	18043760.00	18043760.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7793680.00	7,793,680.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6500000.00	6500000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		

3.АУДИТЫН ТАЙЛАН

3.1. Ерөнхий зүйл

Ус цаг уур орчны шинжилгээний төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг дарга А.Энхзаяа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл,

анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд бараа материалын зарцуулалт, ур чадварын болон улирлын мөнгөн урамшуулал, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дүгээр сарын 13-наас 2021 оны 02 дугаар сарын 21-ний хооронд Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ц.Гантулга хариуцаж хэрэгжүүлэв.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Ус цаг уур орчны шинжилгээний төв нь “Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд ус цаг уур орчны шинжилгээний үнэн зөв мэдээллээр хэрэглэгчдийг хангах байгаль цаг агаарын болзошгүй аюул орчны ноцтой бохирдлоос урьдчилан сэрэмжлүүлэх цаг аргаар уур амьсгалын таатай орчныг бий болгох нийгмийн хэрэгцээ хангахад оршино.” гэсэн зорилтыг дэвшүүлэн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- *Нутаг дэвсгэртээ хууль тогтоомжийг хэрэгжүүлэх*
- *Засгийн газрын шийдвэр харьяалах дээд шатны шийдвэрийг гүйцэтгэлийг хянах*
- *Цаг уур орчны шинжилгээний газрын даргын тушаал, шийдвэрийг хэрэгжүүлэх*

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт*
- *Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”*
- *Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 183 тоот “бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”*
- *Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 10 тоот “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай*
- *Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн А/170 тушаалаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримт*
- *Байгаль орчин шинжилгээний лабораторийн Стандарт хэмжил зүйн ерөнхий газрын шинэ стандартууд*

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Ус цаг уур орчны шинжилгээний төвийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Цаг уур орчны хяналт шинжилгээний газрын дотоод аудит болон аймгийн ЗДТГ-ын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар 2020 онд тус байгууллагад дотоод хяналт хийгдээгүй байна.

Байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд БАГА гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлын 1150397.6 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 11503.9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон.

Харин гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардал 1766428.3 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 17664.3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцлоо.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Ус цаг уур орчны шинжилгээний төвийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 55434,9 мянган төгрөгөөр буюу 6.6 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
АВЛАГА	670,0	0.00	(-670,00)
БАРАА МАТЕРИАЛ	113976,7	94919,7	(19057.7)
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	839114.4	803406.1	(35708.3)
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	953761.1	898326.2	(55434.9)
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0	0.00	(0)
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	953761.1	898326.2	(55434.9)
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	953761.1	898326.2	(55434.9)

Өнгөрсөн оны авлага барагдсан, бараа материалын дансны үлдэгдэл 19057,7 мянган төгрөг буурсан нь болж шилжүүлэн авсан 37484.4 төгрөг төсвийн хөрөнгөөр худалдан авсан 44241.4 мянган төгрөгийн бараа материал нэмэгдэж тайлант онд бараа материал 100782,9 мянган төгрөгний бараа материалын зарлагадсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 839114,4 мянган төгрөг, оны эцэст шилжүүлэн авсан авто машин 56267.6 мянган төгрөг мотоцикл 2400.0 мянган төгрөг, тоног төхөөрөмж 39082.1 мянган төгрөг нийт 98169.5 мянган төгрөг нэмэгдэж, тоног төхөөрөмж 61396.4 мянган төгрөг акталсантай холбоотойгоор, тайлант оны эцсийн үлдэгдэл хөрөнгө 803406.4 мянган төгрөг болсон байна.

Өр төлбөр оны эхэнд өргүй тайлант онд өр төлбөр үүсээгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны оны эхний үлдэгдэл 1221235.4 мянган төгрөг байсан нь тайлант онд өөрчлөлтгүй байна.

Ус цаг уур орчны шинжилгээний төвийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх онд 1212201.3 мянган төгрөг, тайлант онд 1710993.4 мянган төгрөг буюу 71.0 хувиар өссөн байна.

Дээрх үзүүлэлт нь өмнөх онд урсгал үйл ажиллагааны санхүүжилт 1089348.9 мянган төгрөг, тайлант онд 1542082.5 мянган төгрөг болж өссөн нь тэтгэвэр тэтгэмж, бараа үйлчилгээний зардал нэмэгдсэнтэй холбоотой байна

Нийт зардал өмнөх оноос 452733.0 мянган төгрөгөөр буюу 69.0 хувиар өссөн нь өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, шимтгэлийн зардал 199073,1 сая төгрөг буюу 93.6 хувь, тогтмол зардал 3967.5 мянган төгрөг буюу 89.0 хувиар, хангамж бараа материалын зардал 86.0 мянган төгрөг буюу 268.6 хувиар өссөн, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж 618.1 мянган төгрөг буюу 94.0 хувь, нэг удаа удаагийн мөнгөн тэтгэмж 246911.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн, эд хогшил, урсгал засварын зардал 2077.3 мянган төгрөг буюу 72.0 хувиар өссөн байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт:

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг өмнөх оноос цалингийн нэмэгдэл урамшуулал, тэтгэвэр тэтгэмж, бараа үйлчилгээний зардлын өсөлтийг тооцож 452733.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, нийт зарлагыг 1542082.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн гүйцэтгэл:

Тайлант онд 1545889.7 мянган төгрөгийн төсөв баталснаас 1545889.7 мянган төгрөгийг улсын төсвөөс, санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1542082.5 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлого 14.8 мянган төгрөг урсгал үйл ажиллагаанд 1542082.5 мянган төгрөгийг зарцуулж 2057.1 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1540025.4 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нь бичиг хэргийн зардал 1.7 мянган төгрөгөөр, БҮТЭЗ 40.3 мянган төгрөг Дотоод албан томилолт 260.9 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 504.5 мянган төгрөгөөр, даатгалын үйлчилгээ 95.4 мянган төгрөгөөр газрын төлбөр 54.0 мянган төгрөг хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардал 91.5 мянган төгрөг тэтгэмж 1009.2 мянган төгрөг хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогыг 370.0 мянган төгрөг буюу 12.3 хувиар давуулж биелүүлсэн орлогыг мөн төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилт:

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт тайлангийн тайлангаар Засаг даргын тамгын газраас цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаанд 15.0 сая төгрөг ЗДТГазраас тэргүүний байгууллагаар шалгарсны шагнал 0.5 мянган төгрөг агаарын бохирдолтын тооллого 3043.7 мянган төгрөг, ЗДТГазраас ХАА-н харуулын ажиглалтын талбайн өргөжилт 6.0 сая төгрөг ЦУОШГазраас агаарын бохирдолтын шинжилгээ, цөлжилтийн судалгааны ажилд 7793.6 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 134 мэдээллээс хугацаандаа оруулсан 133 мэдээлэл, 1 мэдээллийг мэдээлээгүй, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш дүн бүхий орлого буюу сар бүрийн санхүүжилтийн орлого, зарлагын 28 гүйлгээ гарсныг тухай бүр шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 5000.0 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгөгдөж зөвлөмжийн хэрэгжилт 70 хувьтай байна.

Хүснэгт 4 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт /мянган.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2			3500.0			
Нийт дүн	2	5000.0		3500.0	-	-	-

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 7703.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 1212.1 мянган төгрөгийн төлбөрийн акт, 6491.5 мянган төгрөгийн албан шаардлага, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаа илэрсэнгүй.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 7703.6 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчилд 1212.1 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 6491.5 мянган төгрөгийн 1 албан шаардлага бичиж хүргүүлээ.

1.Сумдын өртөөний нүүрсний норм тооцож тооцоо бодоогүй бөөнд нь зарлагадсан, нүүрс асаах аргалыг их хэмжээгээр нөөцөлсөн татан авсан, төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн тэтгэмжийг нэг ажилтанд 1 сарыг илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.7-д "төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийг Нягтлан бодох хуулийн холбогдох дансанд бүртгэх,тайлагнах" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас өмнө хянан, баталгаажуулах" гэсэн хуулийн заалт "Засгийн газрын 2019 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн 7 дугаар тогтоолоор баталсан"Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам"-ын 3.2-д "Төрийн албанд ажилласан хугацааг тухайн байгууллагын хүний нөөцийн асуудал хариуцсан нэгж буюу албан тушаалтан тооцож олгоно. Төрийн албанд ажилласан хугацааг хуанлийн бүтэн жилээр тооцно." гэсэн заалт, Аудитын олон улсын стандартын -300, "Үнэн зөв байдал", "Иж бүрэн" байх гэсэн батламж мэдээдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

2. Албан ажлын хэрэгцээний автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтан суудлын автомашины хот доторх нэг өдрийн км-ийн нормыг хэтрүүлсэн,жолоочийн тооцоо бодохдоо машины спидометрийн заалт баримтлаагүй, жолоочийн зарим замын хуудсанд хэрэглэгчийн зөвшөөрсөн гарын үсэггүй зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн

6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас өмнө хянан, баталгаажуулах" гэсэн хуулийн заалт, ЗГ-ын 2015 оны 184 дүгээр тогтоолын холбогдох заалт, Аудитын олон улсын стандартын -300, "Үнэн зөв байдал", "Иж бүрэн" байх гэсэн батламж мэдээдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

3.0. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Дотоод хяналттай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Ур чадварын нэмэгдлийг ажлын үр дүнг бодитой үнэлээгүй, хавтгайруулан олгосон байна. Энэ нь Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан журмын "3" дахь заалтыг зөрчсөн байна.

1.2 Эрсдэл: Төсвийн хөрөнгийн үр өгөөж буурах, дотоод хяналт хэрэгжүүлээгүй байх

1.2 Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", ЗГ-ын 382 дугаар тогтоолыг мөрдөж ажиллах

1.3 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ

Огноо: 2021	Аудитын нэр: Аудит	Ус цаг уур орчны шинжилгээний төвийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код: ХОА-2021/111/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Ус цаг уур очны шинжилгээний төв		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Сумдын ертөөний нүүрсний норм тооцож тооцоо бодоогүй бөөнд нь зарлагдсан, нүүрс асаах аргалыг их хэмжээгээр нөөцөлсөн	1212.1	Төлбөрийн акт		

	Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжийг нэг ажилтанд 1 сарыг илүү олгосон			Дарга , нягтлан бодогч	А.Энхзаяа Б.Батчимэг
2	Албан ажлын хэрэгцээний автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтан суудлын автомашины хот доторх нэг өдрийн км-ийн нормыг хэтрүүлсэн,жолоочийн тооцоо бодохдоо машины спидометрийн заалт баримтлаагүй, жолоочийн зарим замын хуудсанд хэрэглэгчийн зөвшөөрсөн гарын үсэггүй	6491.5	Албан шаардлага		
3	Ур чадварыг ажлын үр дүнг бодитой үнэлээгүй, хавтгайруулан олгосон байна.	0	Зөвлөмж өгөх		
Дүн		7703.6			

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР